

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

“144¹ дүгээр зүйл.Хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

144¹.1.Хүүхэд үрчлэн авах хүсэлтийг хүүхдийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

144¹.2.Хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтэд хүүхэд үрчлэх болсон шалтгааныг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримт, эрх бүхий байгууллагын үнэлгээ, дүгнэлтийг хавсаргана.

144¹.3.Зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч болон хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

144¹.4.Шүүх хүүхдийг үрчлүүлэх шийдвэр гаргахдаа гадаад, дотоод Зөвлөлийн саналыг харгалзан шийдвэр гаргана.”

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 144.1.4 дэх заалтын “хүүхэд” гэсний дараа “үрчлүүлэх,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“132.4.Гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон, эсхүл сүүлийн таваас доошгүй жил хамтран амьдраагүй болохыг шүүх тогтоосон бол шүүгч энэ хуулийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.2, 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/127 дугаар зүйлийн 127.3, 127.4, 127.5 дахь хэсэг:

“127.3.Хүүхдийн хуваарьт хөрөнгийг эцэг, эх нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулах үүргийг хүлээнэ.

127.4.Эцэг, эх нь гуравдагч этгээдтэй эрх зүйн харилцаанд орохдоо хүүхдийн хуваарьт хөрөнгийн хувьд өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлж, үр дагаврыг нь хариуцах бөгөөд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлах үйл ажиллагаа явуулсны улмаас түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

127.5.Хүүхэд насанд хүрснээс хойш 10 жилийн дотор өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах эрхтэй.”

2/127 дугаар зүйлийн 127.7 дахь хэсэг:

“127.7.Хүүхдийн хуваарьт хөрөнгөөр эцэг, эхийн бусдын өмнө хүлээх үүргийг барагдуулах, нөхөн төлүүлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 129 дүгээр зүйлийн 129.3 дахь хэсгийн “тодорхойлохдоо” гэсний дараа “гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан, нөхцөл,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний хуулийн 517 дугаар зүйлийн 517.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“517.1.Өвлүүлэгчийг, эсхүл хууль ёсны буюу гэрээслэлээр өвлөгчийг санаатайгаар алсан, эсхүл тэдгээрийн хэн нэгний эсрэг Эрүүгийн хуульд заасан бусад гэмт хэргийг үйлдсэн, эсхүл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол уг гэм буруутай этгээд хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөх эрхээ алдана.”

4 дүгээр зүйл.Иргэний хуулийн 127 дугаар зүйлийн 127.3 дахь хэсгийн дугаарыг “127.6” гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Иргэний хуулийн 125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсгийн, 126 дугаар зүйлийн 126.2.4 дэх заалтын, мөн зүйлийн 126.3 дэх хэсгийн, мөн зүйлийн 126.4 дэх хэсгийн, 129 дүгээр зүйлийн 129.1.3 дахь заалтын “бусад” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Иргэний хуулийн 132, 133 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 90 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 90.8, 90.9, 90.10 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

“90.8. Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 44.2-т заасан арга хэмжээ авсан боловч төлбөр төлөгч хөрөнгө, орлогогүй, хөдөлмөр эрхлэх боломжтой боловч хөдөлмөр эрхэлдэггүй болох нь тогтоогдсон бол төлбөр төлөгчийн мэдээллийг харьяалах хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шилжүүлж, хамтран ажиллана.

90.9. Энэ хуулийн 90.8-д заасан төлбөр төлөгчийн мэдээллийг харьяалах хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шилжүүлэх, хамтран ажиллах журмыг хөдөлмөрийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

90.10. Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 90.8-д заасан арга хэмжээг нэг удаа хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.5 дахь хэсэг нэмсүгэй:

“31.5. Гэр бүлийн тухай хуулийн 22.3-т заасан урьдчилсан тэмдэглэлийг гэрлэгчид улсын бүртгэлийн байгууллагад хүсэлт гаргаж, эсхүл нотариатчаар дамжуулан эрхийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.”

2 дугаар зүйл. Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5, 31.6 дахь хэсгийн дугаарыг “31.6, 31.7” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 9, 10 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

“9.Хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эх хүүхэдтэй уулзах үүргээ удаа дараа хэрэгжүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж, долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

10.Хүүхдээс тусдаа амьдрах эцэг, эхийн хүүхэдтэйгээ уулзах эрх, үүргээ хэрэгжүүлэхэд удаа дараа саад учруулсан бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт “6.20 дугаар зүйлийн 6” гэснийг “6, 9, 10” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/8¹ дугаар зүйл:

“8¹ дугаар зүйл.Гэрлэлт хүчин төгөлдөр бус болсны бүртгэл

8^{1.1}.Гэр бүлийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор гэрлэлт хүчин төгөлдөр бус болсны бүртгэлд тухайн хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүх бүртгүүлнэ.

8^{1.2}.Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан энэ хуулийн 8^{1.1}-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор гэрлэлт хүчин төгөлдөр бус болсны бүртгэлийг хөтөлнө.”

2/12 дугаар зүйлийн 12.2.6 дахь заалт:

“12.2.6.хүүхэд долоон насанд хүрсэн бол хүүхдийн өөрийн зөвшөөрөл.”

3/6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт:

“6.1.4.хэрэв нөхөн үржихүйн туслах технологийг ашиглаж хүүхэдтэй болсон бол Гэр бүлийн тухай хуулийн 27.1-д заасан гэрээ.”

4/12 дугаар зүйлийн 12.10 дахь хэсэг:

“12.10.Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчилсөн шийдвэрийг хүчингүй болсонд тооцсон тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн улсын бүртгэгч тухайн бүртгэлд өөрчлөлт оруулж, төрсний бүртгэлийг сэргээнэ.”

2 дугаар зүйл.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9 дүгээр зүйл.Гэрлэлт сэргээсний бүртгэл

9.1.Гэр бүлийн тухай хуулийн 17.3-т заасан шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүх гэрлэлт сэргээсний бүртгэлд бүртгүүлнэ.

9.2.Иргэнийг сураггүй алга болсонд тооцсон, нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчингүй болсон бол тухайн шийдвэрийг энэ хуулийн 9.1-д заасан баримт бичигт хавсаргана.

9.3.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор тухайн хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүх бүртгүүлнэ.

9.3.Улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтан энэ хуулийн 9.1, 9.2, 9.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор гэрлэлт сэргээсний бүртгэлийг хөтөлнө.”

3 дугаар зүйл.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “13 дугаар зүйлд” гэснийг “12.1-д” гэж, мөн зүйлийн 8.6 дахь хэсгийн “нас барсны бүртгэлд” гэснийг “Гэр бүлийн тухай хуулийн 10.1.1 болон 10.1.2-т заасан тохиолдол бий болсон” гэж, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “эрх бүхий этгээдийн” гэснийг “үрчлүүлэх тухай шүүхийн” гэж, “1” гэснийг “таван” гэж, мөн зүйлийн 11.6, 11.7, 11.8 дахь хэсгийн дугаарыг “11.1, 11.2, 11.3” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3, 11.4, 11.5 дахь хэсэг, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг